

ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН 2025 ОНЫ
“3 ДАХЬ УДААГИЙН АЗИЙН ЗАЛУУЧУУДЫН НААДМЫН ПҮМСЭ ТӨРӨЛД
МОНГОЛ УЛСАА ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТАМИРЧИН СОНГОН
ШАЛГАРУУЛАХ СОРИЛ ТЭМЦЭЭН”-ИЙ ЗААВАР

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- Таеквондогийн спортыг сурталчлах
- 2025 оны 10-р сард Бахрейн улсад зохион байгуулагдах 3 дахь удаагийн Азийн Залуучуудын наадамд эх орноо төлөөлөн оролцох тамирчдыг сонгон шалгаруулах

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Зохион байгуулагч	Монголын таеквондогийн холбоо
Холбоо барих утас	7015-5500, 8619-0073
Имэйл	mongolitaekwondo@gmail.com
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Огноо	Хөтөлбөр	Байршил
04-р сарын 07-18	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
04-р сарын 25	Техникийн зөвлөгөөн	Монголын таеквондогийн Үндэсний шигшээ багийн заал
04-р сарын 26-27	Тэмцээн	Дотоод хэргийн их сургууль

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.

ШААРДЛАГА:

Тэмцээнд оролцогч **Тамирчдад** Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаардлага тавигдана.

1. Оролцогч тамирчин Куккивоны хар бүс, дантай байна
2. Тамирчин нь Монголын таеквондогийн холбооны цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна

Багт тавигдах шаардлага:

1. Тэмцээнд оролцох байгууллага нь Монголын таеквондогийн холбооны албан ёсны гишүүн байгууллага байна
2. Оролцогч байгууллага нь татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх

Дасгалжуулагчид тавигдах шаардлага:

1. Монголын таеквондогийн холбооны дасгалжуулагчийн В зэрэгтэй эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч тамирчдыг дэвжээнд авч гарах эрхтэй
2. Хагас шигшээ болон шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас өмсөх шаардлагатай
3. Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд хяналт тавих нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг
4. Тэмцээний үеэр дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно

1. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ:

- I. Тэмцээнд оролцогчид хүйс, насаар хязгаарлагдахгүй бол дээд тал нь хоёр ангилалд өрсөлдөх боломжтой.
- II. Насны хувьд:
 - Залуучууд (15-16 нас) 2009-2010 онд төрсөн тамирчид

2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУГАЦАА:

- I. Үндсэн пүмсэ: 90 секунд хүртэл
- II. Завсарлага: Эхний пүмсэ болон хоёр дахь пүмсэ хоорондын зай хамгийн багадаа 30 секунд

3. ТӨРӨЛ:

Үндсэн пүмсэ
Эрэгтэй ганцаарчилсан
Эмэгтэй ганцаарчилсан
Эрэгтэй баг (3 эрэгтэй)
Эмэгтэй баг (3 эмэгтэй)
Холимог хос (1 эрэгтэй, 1 эмэгтэй)

Гүйцэтгэх пүмсэ:

Нас	Ангилал	Гүйцэтгэх пүмсэ
Залуучууд 15-16	А ангилал	Таегүк 5,6,7,8 жан, Корёо, Гимган, Тебек, Пёнвон

Тэмцээн хасагдах системээр явагдана. А ангиллын гүйцэтгэх 2 пүмсэг санамсаргүй байдлаар сонгож, тэмцээний өмнөх багийн ахлагч нарын хурал дээр мэдэгдэнэ.

4. БАГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- I. Нэг байгууллагаас орох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй.
- II. Бүртгэлийн хугацаа хэтэрсэн багийн мэдүүлгийг хүлээн авахгүй.
- III. Тэмцээнд оролцох байгууллага нь Монголын таеквондогийн холбоонд татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх.

5. БҮРТГЭЛ:

- I. Бүртгэлийг цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болон www.mongol-taekwondo.com хаягаар бүртгүүлнэ.
- II. Оролцогчийн хураамжийг зөвхөн цахимаар шилжүүлнэ.

6. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ, БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:

- I. Бүртгэлийн хугацаа: 2025 оны 04-р сарын 07-18-ны өдрийн 18:00 цаг хүртэл
 - Дэвжээний төлбөр 50.000 (тавин мянга) төгрөг
 - Хоёр төрөлд оролцох тамирчны хувьд дэвжээний төлбөр дээр 10.000 (арван мянга) төгрөг нэмэгдэнэ.

7. ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН ГАРГАХ:

- Азийн Залуучуудын наадамд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах сорил тэмцээний жин тус бүрт түрүүлсэн тамирчинд тус наадамд Монгол улсаа төлөөлөн өрсөлдөх эрхийг олгоно. 2-р байрт шалгарсан тамирчинд сэлгээний тамирчны эрх олгогдоно. Багийн дүн тооцохгүй. Медаль олгохгүй.

8. ӨМСГӨЛ:

- Тэмцээнд оролцох тамирчин нь пүмсэ тобог өмсөх шаардлагатай.

Монгол улсад хэрэглэгдэх таеквондогийн өмсгөлийн стандарт



ПҮМСЭ

Пүмсэ буюу тоот дасгалын тамирчид Ү төрлийн задгай энгэртэй өмсгөл өмсөнө. 15 хүртэлх насны тамирчид хүйснээс хамааран улаан болон хөх өнгийн өмд, улаан, хар судал бүхий энгэрийн эмжээр бүхий дээд өмсгөл өмсөнө. Өндөр дан (Хар бүс 7-р дан болон түүнээс дээш) болон ахмад настай мастерууд ердийн цагаан өнгөний оронд алтан шар өнгийн өмсгөл өмсөх эрхтэй байдаг байна.



ГҮП, ПҮҮМ ЗЭРЭГ
15 хүртэлх насны тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.
Өмдний тухайд:
Эрэгтэй: Хөх өнгө
Эмэгтэй: Улаан өнгө



ДАН ЗЭРЭГ
16 ба түүнээс дээш настай хар бүстэй тамирчид бэлтгэл болон тэмцээний үеэр өмсөнө.
Өмдний тухайд:
Эрэгтэй: Хар өнгө
Эмэгтэй: Саарал өнгө



МАСТЕР
Хар бүс 7-р дан болон түүнээс дээш дантай мастерууд. Мөн түүнчлэн ахмад настай мастер тамирчид Алтан шар өнгийн өмсгөл өмсөнө.

9. БАГИЙН АХЛАГЧДЫН УУЛЗАЛТ БОЛОН СУГАЛАА

1. Багийн ахлагч нар 04-р сарын 25-ны өдөр хуралдана.
2. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -